



ТӨВ АЙМГИЙН УГТААЛ СУМЫН СУРГУУЛЬ

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272582

[И-мэйл](#)

Аудитын багийн ахлагч Аудитор

Ц.Базарсад

Утас: 70272287

И-мэйл Bazaraatsend@yahoo.com

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4
• Гол шийдлүүд	7
• Залруулаагүй алдаа	7
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	7
• Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт.....	7
• Аудитын санал дүгнэлт	8

Ерөнхий боловсролын сургуулийн 2013 оны Санхүүгийн тайланд

ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид ЕБС-ийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба ЕБС-ийн төсвийн шууд захирагч энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Угтаал сумын сургууль тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

1. Санхүүгийн ажилтнуудаас зөвхөн нягтлан бодогч санхүүгийн программ ашиглаж байна. Эд хариуцагч санхүүгийн программ ашиглахгүй байгаа ба няравын тайланг нягтлан бодогч өөрөө шивж оруулж байна.
2. Тооллогын комисс нь тооллогыг огт хийгээгүй, эрсдлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. ТБОНӨТХуулийн 70-р зүйлийн 2.1-д үндсэн хөрөнгийг 12-р сарын 1-нээс, 2.4-д мөнгөн хөрөнгө, шатах тослох материал, бараа, сав боодлыг сар бүрийн 1-нээс хийнэ гэсэн заалтуудыг зөрчин, тооллогын комиссын эрх, үүргийг мөрдөж ажиллаагүй байна.
3. Хүүхдийн хоолны хэмнэлт төвлөрүүлээгүй 3728.7 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр акт бичигдсэн.
4. Энэ нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай

хуулийн 17 дугаар 1.7-д “байгууллагын төсвийн санхүүжилтийг үр ашигтай явуулах” гэсэн заалт, БСШУСайд, ССайдын 2009-12-14-ны 560/276 тоот тушаалаар батлагдсан Хүүхдийн цэцэрлэгийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол, МСҮТөвийн суралцагчдын тэтгэлэгийн зардлын хэмнэлтийг тооцох, төвлөрүүлэх, зарцуулах журмын 2-ын 4-д “Төв төрийн сан дахь Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хэмнэлтийн дансанд зардлын хэмнэлтийг төвлөрүүлнэ”, 6-д “Цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нь тухайн улиралд гарсан зардлын хэмнэлтийг дараа улирлын эхний сарын 10-ны дотор, 4-р улирлын зардлын хэмнэлтийг 12 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэх дансанд шилжүүлж байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төсвийн шууд захирагчаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

- Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа
- Тэргүүлэх Аудитор 2014.03.16-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ерөнхий нягтлан бодогч Д.Нямдагва бидэнтэй хамтран ажилласан ажилчдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Төв Аймгийн Аудитын Газар

2014.03.15

Танилцуулга

1. Бид Аймгийн Угтаал сумын сургуулийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Аймгийн Угтаал сумын сургуулийн шууд захирагч энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Угтаал сумын сургууль тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийхэд

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Аймгийн Угтаал сумын сургуулийн хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Аймгийн Угтаал сумын сургуулийн захиралд тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Аймгийн Угтаал сумын сургуулийн удирдлагын анхаарлыг хандуулж байна.

1. Санхүүгийн дотоод хяналтын талаар

- Байгууллагын дотоод хяналтыг 2011.03.02-ны өдрийн 17 тоот тушаалаар батласан байна. Дотоод хяналт шалгалтыг явуулах журмыг батлан төлөвлөгөө удирдамж гарган ажилласан гэх боловч хийсэн ажлын тайлан материалыг үзээгүй болно.

2. Орлогын талаар

- 2013 оны батлагдсан төлөвлөгөөгөөр урсгал санхүүжилт 553729.9 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 145.3 мянган төгрөг нийт 553875.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг зарцуулахаас гүйцэтгэлээр үндсэн бу үйл ажиллагааны орлого 1129.7 мянган төгрөг, 553729.9 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч нийт 554859.6 мянган төгрөг зарцуулсан байна.
- Үндсэн бус үйл ажиллагааны орлогын 145.3 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэлээр 1129.7 мянган төгрөг оруулж орлогын төлөвлөгөөг 984.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.
- Энэ нь үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрдүүлэх талаар гаргасан эрх зүйн акт болон журам байхгүй боловч сургуулийн хуучин цайны газрын

байранд иргэн Гантөмөртэй түрээслэн багш ажилчдыг цайгаар хангахаар сарын 45.0 мянган төгрөгийн гэрээ хийсэн байна. Мөн оюутны дадлагын хүүхдийн байрны хөлс 100.0 мянган төгрөг, 434.7 мянган төгрөгийн хоолны орлого орсон байна.

3. Мөнгөн хөрөнгийн талаар

Харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад төрийн сангийн 141815101 данс үлдэгдэлгүйгээр тайлагнасан боловч хяналтын түвшингийн хуулга, төрийн сангийн үлдэгдлийн баталгаа авч ирээгүй байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаар 554859.6 мянган төгрөгийн орлого, 554859.6 мянган төгрөгийн зарлагаар тайлагнасан байна. Төрийн сангийн хяналтын түвшингийн хуулгаар орлого 553729.9 мянган төгрөг, зарлага 573353.8 мянган төгрөг, орлогоос бууруулах бичилт хийгдсэн гүйлгээ 19623.9 мянган төгрөг цэвэр дүн 553729.9 мянган төгрөг байна.

Багш Д.Галягийн 5745088234 тоот хамтын сангийн хаан банкны дансаар сургуулийн 80 жилийн ойн хандивыг цуглуулан зарцуулсан байна. Хандивын дансны эхний үлдэгдэл 4682.8 мянган төгрөг дээр бэлэнээр 57210,8 мянган төгрөгийн орлого дансаар, бэлэнээр 6000.0 мянган төгрөг нийт 63210.8 мянган төгрөг нэмэгдэж, гүйцэтгэлээр 63210.8 мянган төгрөгийг зарцуулж, эцсийн үлдэгдэл 1658.6 мянган төгрөг үлдэгдэлтэй байна. Үүнээс:

- Хандивын уулзалтанд 3065.0 мянган төгрөг
- Номын сангийн цонхны үнэнд 443.5 мянган төгрөг
- Давхар бүрт 1 самбар, ажилчдын мэдээллийн самбарт 1337.0 мянган төгрөг
- Аймгийн 90 жил ойд 500.0 мянган төгрөг
- Урлагийн тоглолтын хувцасанд 2590.0 мянган төгрөг
- Тавилга худалдаж авахад 5592.0 мянган төгрөг
- Өндөрлөг хийхэд 3000.0 мянган төгрөг
- Ширээ сандал ангид 2610.0 мянган төгрөг
- Урлагийн гутал 372.0 мянган төгрөг
- Урилга дурсамжинд 2000.0 мянган төгрөг
- Урлагийн тоглолт 15000.0 мянган төгрөг
- Номны үнэнд 6064.0 мянган төгрөг
- Хүүхдийн гимнастикийн хувцас, бөхийн өмсгөл, хүлээн авалтанд 8091.4 мянган төгрөг
- Аяагны үнэнд 2430.0 мянган төгрөг
- Хулдаасан хэвлэл 264.0 мянган төгрөг
- Медаль, магнайвч материалд 1002.0 мянган төгрөг
- Дэвтэр балны үнэ 300.0 мянган төгрөг
- Баяр наадмын шагналд 5620.0 мянган төгрөг
- Баярын үйл ажиллагааны концертын арга хэмжээнд 2700.0 мянган төгрөг
- Хүлээн авалтын тогоочид 230.0 мянган төгрөг тус тус нийт 63210.8 мянган төгрөг зарцуулж, үүнээс үндсэн хөрөнгийн дансанд 8202.0 мянган төгрөг, бараа материалд 3927.0 мянган төгрөгийг хандиваар ирсэн хөрөнгөөр бүртгэсэн байна

Харилцахын гүйлгээнүүдийн баримтын бүрдэлийг шалгахад 12-р сард анхан шатны баримтын бүрдэлгүй орлогоос бууруулах бичилт хийж гаргасан гүйлгээнүүд:

- 2013.12.04-ны 381 тоот төлбөрийн хүсэлтээр Ч.Одонцэцэгийн хаан банкны 5745048451 тоот дансанд махны үнэ гэж 72450 төгрөгийг 14020-с гаргасан

- 2013.12.04-ны 382 тоот төлбөрийн хүсэлтээр Нүрээдэд номын үнэ гэж 3900 төгрөгийг 29997 зардлаас гаргасан
- Нярав Наранцэцэгийн хаан банкны 5013020732 тоот дансанд 2013.12.10-нд 386 тоот төлбөрийн хүсэлтээр бичиг хэргийн зардлаас 40.0 мянган төгрөг, 63.7 мянган төгрөг
- Дээрх дансанд 2013.12.16-нд бичиг хэргийн зардлаас 63.7 мянган төгрөг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр
- Нярав Наранцэцэгийн дансанд материалын үнэ төлөв гэж цаад газрын нэхэмжлэх падан байхгүйгээр 51.0 мянган төгрөгийг нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас, 313.2 мянган төгрөгийг үдийн цайны зардлаас
- 2013.12.16-нд 388 тоот төлбөрийн хүсэлтээр проекторын үнэнд гэж 575380 төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас, 84620 төгрөгийг орлого бууруулж 29997
- Ану сервист 12562.9 мянган төгрөгийг цаад газрын нэхэмжлэхгүйгээр шилжүүлсэн
- Холбооны газарт 61127 төгрөг шилжүүлэхдээ холбооны зардлаас 42.3 мянган төгрөг, төлбөр хураамж бусад зардлаас 18.8 мянган төгрөг шилжүүлэхдээ ЗЭБ-1 маягтаар зөвшөөрөлгүйгээр шилжүүлсэн
- Б.Нямаад 160.0 мянган төгрөг орлогоос бууруулах бичилтээр бэлэн мөнгө олгосон нь юунд зориулж гаргасан нь тодорхойгүй
- Нярав Наранцэцэг 2013.12.23-ны 430 тоот төлбөрийн хүсэлтээр 5013020732 хаан банкны дансаар 278.1 мянган төгрөгийг гаргахдаа орлого бууруулах бичилтээр 110.0 мянган төгрөг, төлбөр хураамж бусад зардлаас 39.4 мянган төгрөг, 29997-с 128.7 мянган төгрөг баримтын бүрдэлгүйгээр материалын үнэ төлөв гэж гаргасан

Сургуулийн хоолны зардал төсвийн гүйцэтгэлийн тайлангаар хоолны 34897.4 мянган төгрөг, үдийн цайны 16583.3 мянган төгрөгийн зардлыг үлдэгдэлгүйгээр зарцуулсан байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаар гарсан зардлыг бараа материалын тайлангийн орлоготой тулган шалгахад хоол, үдийн цайнд 51480.7 мянган төгрөг зарцуулж, 48239.3 мянган төгрөгийн орлого авч зөрүү 3241.3 мянган төгрөгийг тодруулахад урьд оны актын төлбөрт 3361.9 мянган төгрөг төлсөн байна.

Тайланд онд дотуур байрны хүүхдийн тоо 16042 хүүхэдийг өдөрт 2315 төгрөгөөр тооцож нийт 37137.2 мянган төгрөгийг зарцуулахаас 35207.9 мянган төгрөг зарцуулж 1929.2 мянган төгрөгийг дутуу зарцуулж хэмнэсэн байна.

Үдийн цайнд хүүхдийн тоо 29395, өдөрт 600 төгрөгөөр тооцож нийт 17637.0 мянган төгрөг зарцуулахаас 15837.5 мянган төгрөг зарцуулж 1799.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулж хэмнэсэн байна. Нийт үдийн цай, хоолны хэмнэлт 3728.7 мянган төгрөгийн хэмнэлтийг оны эцэст төвлөрүүлээгүй байгаад акт бичигдсэн.

4. Бараа материалын талаар

Бараа материалын оны эхний үлдэгдэл 48072.8 мянган төгрөг, тайланд онд 60956.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 59039.6 мянган төгрөгийн материал зарцуулж, эцсийн үлдэг 49989.6 мянган төгрөг гарсан байна.

Тооллогын комиссыг 2013.12.17-ны 43 тоот захирлын тушаалаар комиссын дарга Г.Алтангэрэл захирал, гишүүд Б.Нямдагва ня-бо, Б.Нямаа нярав, Г.Нүрээд номын санч, Б.Төгсбаатар сахиул нарын бүрэлдэхүүнтэйгээр томилсон байна.

Тооллогын комисс нь тооллогыг огт хийгээгүй, эрсдлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. ТБОНӨТХуулийн 70-р зүйлийн 2.1-д үндсэн хөрөнгийг 12-р сарын 1-нээс, 2.4-д мөнгөн хөрөнгө, шатах тослох материал, бараа, сав боодлыг

сар бүрийн 1-нээс хийнэ гэсэн заалтуудыг зөрчин, тооллогын комиссын эрх, үүргийг мөрдөж ажиллаагүй байна.

5. Үндсэн хөрөнгийн талаар

Тайланд онд 42892.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн. Төсвийн хөрөнгөөр 660.0 мянган төгрөгийн проектор, үнэ төлбөргүй хандиваар 41828.3 мянган төгрөгийн хөрөнгө авсан. Үнэ төлбөргүй авсан хөрөнгийн задалбал:

- Байгаль хамгаалах санд төсөл бичиж тавилга эд хогшил 260.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 1420.0 мянган төгрөгийн хөрөнгө авсан.
- Япон багш Эндогоос машин тоног төхөөрөмжинд гал тогооны төхөөрөмж 4639.9 мянган төгрөг
- Сургуулийн 80 жилийн ойн хандиваар ирсэн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшилд 8202.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан
- Сургуулийн 80 жилийн ойд хандивт хөрөнгөөр ирсэн 23541.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил хүлээн авсан.

Хяналтын сорилоор “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д “Эд хөрөнгийн тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хариуцна”. 11 дүгээр зүйлийн 2-ын 1-д “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллого хийнэ” гэсэн заалтыг биелүүлж тооллого хийсэн боловч тооцоо бодож үр дүнг тооцоогүй байна. Иймд хөрөнгийн тооллогыг үнэн зөв хийсэн гэх итгэл төрөхгүй байна.

Элэгдлийг шалгахад элэгдлийг программаар бодуулсан байна.

6. Бараа үйлчилгээний зардал

Нэмэлт санхүүжилтийн авьяас хөтөлбөрийн 1289.5 мянган төгрөгийн багшийн урамшуулал ирсэн боловч шууд зардалд бичиж тайланд тусгаагүй байна. Мөн гүйцэтгэлийн үзэхэд 5 багшид олгосон байна..

7. Авлага, өглөгийн талаар

Авлага өглөгийн тулган баталгаажуулалт хийхэд харилцагч байгууллагуудтай Цахилгаан эрчим хүч, Нийгмийн даатгал, Шуудан холбоо, Петровис ХХК үлдэгдэлгүйгээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

8. Цалингийн талаар

Цалингийн нэмэгдэл болон илүү цагийн олголтын байдлыг шалгахад сургалтын менежерийн цагийн тооцоо болон нэмэгдлийн тооцоог хийсэн байна. Цагийн балансыг үндэслэн цалингаа цалингийн программаар бодож хэвшсэн байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 8 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

6. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.
- Хөрөнгө, бараа материалын тооллогыг хуулийн хугацаанд чанартай хийж гүйцэтгэж байх
 - Хүүхдийн хоол, үдийн цайны хоолны ордерыг өдөр тутам бичиж дүгнэж байх
 - Анхан шатны баримтын бүрдэлийг анхаарч ажиллах
 - Буцаж ирсэн гүйлгээ болон листний орлогыг мөнгөн гүйлгээний журналд бууруулах бичилтээр харуулж байх.

7. Эдгээр асуудлуудыг ААГ болон Угтаал сумын сургууль авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

8. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг.

Тайлбар мэдүүлгийн захидал

9. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд сургуулийн удирдлагаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

10. Аймгийн Аудитын газраас тус тайланд зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

ААГ

2014.03.15